



Гадаад Харилцааны Яам



Стратеги Судалгааны Хүрээлэн

**ЗҮҮН ХОЙД АЗИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛААРХ  
“УЛААНБААТАРЫН ЯРИА ХЭЛЭЛЦЭЭ”**

Олон улсын IX бага хурал  
2024 оны 06 дугаар сарын 6-7

Гадаад Харилцааны Яамны “Зөвшилцөл” танхим

**2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр, Пүрэв гараг**

**08:30 - 09:00** Бүртгэл

**09:00 – 09:45** **НЭЭЛТ**

**Модератор:** ГХЯ-ны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал **Батсүрэнгийн Мандхай**

**Нээлтийн үг:**

Монгол Улсын Гадаад харилцааны сайд **Батмөнхийн Батцэцэг**

Монгол Улсын ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэнгийн захирал, доктор **Жаргалсайханы Мэндээ**

НҮБ-ын Улс төр, энхийг цогцлоохын асуудал эрхэлсэн орлогч Ерөнхий нарийн бичгийн дарга Роузмари ди Карло (видео мэндчилгээ)

Дурсгалын зураг (нийт оролцогчид, “Номин” танхим)

**09:45-10:00** Кофе завсарлага (ГХЯ-ны “Номин” танхим)

**10:00-12:30 ХУРАЛДААН 1: БҮС НУТГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СОРИЛТ, БОЛОМЖ**

Их гүрнүүдийн геополитик, гео-эдийн засгийн өрсөлдөөн үргэлжилж, Солонгосын хойгийн нөхцөл байдал тодорхойгүйн улмаас Зүүн хойд Азийн аюулгүй байдлын орчин ээдрээтэй хэвээр байна. Энэ хуралдаан бодлого боловсруулагч, эрдэмтэн, судлаач нарт бүс нутгийн аюулгүй байдлын сорилт, боломжийн талаар санал бодлоо солилцох, хэлэлцэх талбар болно.

- *Аюулгүй байдалд нэн тулгамдаж буй сорилт, чиг хандлага юу вэ? Энэ нь бүс нутгийн цаашилбал, олон улсын тогтвортой байдалд богино, дунд болон урт хугацаанд хэрхэн нөлөөлөх вэ?*

**Модератор:** Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн шинжээч, Элчин сайд **Очирын Энхцэцэг**

**Панелист:**

Японы Нийгата мужийн их сургуулийн Зүүн Хойд Азийн Эдийн засаг, Нийгмийн судалгааны хүрээлэнгийн профессор, доктор **Мимура Мицухиро**

Монгол Улсын ҮАБЗ-ийн Ажлын албаны Стратегийн бодлого, дүн шинжилгээний газрын дарга, хурандаа **Доржжүгдэрийн Мөнх-Очир**

БНСУ-ын Үндэсний Аюулгүй Байдлын Стратеги Судалгааны хүрээлэнгийн Умард Солонгос судлалын газрын захирал, доктор **Сан-Юн Бюн**

ОХУ-ын Шинжлэх Ухааны Академийн Дорно дахин судлалын хүрээлэнгийн төвийн дарга, доктор **Александр Воронцов**

Track2Asia, Зүүн Хойд Азийн Эдийн засгийн Форум, Номхон далайн зууны хүрээлэнгийн Удирдах зөвлөлийн гишүүн **Глин Форд**

АНУ-ын Жон Хопкинсийн Олон улс судлалын сургуулийн Хэнри Кессинжерийн төвийн Вильсон Шемидтын Хүндэт профессор **Сергей Радченко**

Асуулт, хариулт

12:30 - 13:30 Өдрийн зоог

### 13:30 – 15:30 ХУРАЛДААН 2: ЗҮҮН ХОЙД АЗИЙН ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Зүүн хойд Азийн бүс нутагт аюулгүй байдлын нэгдсэн механизм үгүй ч итгэлцлийг бэхжүүлэхийн төлөөх хүчин чармайлт цөөнгүй гарч байдаг. Төрийн болон төрийн бус байгууллага ч энэ чиглэлд олон төрлийн санал, санаачилгыг дэвшүүлж, хэрэгжүүлэхийг эрмэлзэж ирсэн. Энэ хуралдаанаар энэ болон бусад бүс нутгийн судлаач, мэргэжилтэн нар итгэлцэл бэхжүүлэх чиглэлд амжилттай хэрэгжиж буй арга хэмжээ, санаачилгын талаарх үзэл бодлоо хуваалцах, өнгөрсөн болон одоогийн үйл явц, тохиолдолд дүн шинжилгээ хийж, бүс нутагт итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээг тогтвортой хэвшүүлэх талаар ярилцана.

- *Улс орнууд итгэлцэл бэхжүүлэх үр дүнтэй арга хэмжээнд хэрхэн хувь нэмэр оруулах вэ? Ямар шилдэг туршлага, арга зам байна вэ?*

**Модератор:** Франц Улсын Парисын Доуфины Их сургуулийн Улс төрийн шинжлэх ухааны профессор **Арнод Ливью**

**Панелист:**

Канадын Ази, Номхон далайн сангийн Судалгаа, стратеги хариуцсан дэд ерөнхийлөгч **Вина Наджибулла**

Олон улсын улаан загалмайн хорооны Зүүн Ази хариуцсан бүс нутгийн төлөөлөгчийн газрын орлогч захирал **Борис Келешевич**

Польшийн Гадаад Хэргийн Яамны Азийн газрын орлогч захирал **Конрад Павлик**

Казахстаны Шинжлэх ухаан, дээд боловсролын яамны Философи, Улс төр, Шашин судлалын хүрээлэнгийн Улс төр судлалын төвийн дэд захирал **Рустем Мустафин**

Сингапурын Ражаратнамын Олон улс судлалын сургуулийн Батлан хамгаалах, Стратегийн судлалын хүрээлэнгийн АНУ-ын хөтөлбөрийн зохицуулагч, судлаач, доктор **Адриан Анг**

НҮБ-ын Монгол дахь суурин зохицуулагч **Тапан Мишра**

Асуулт, хариулт

13:30 – 16:00 **ДУГУЙ ШИРЭЭНИЙ УУЛЗАЛТ** (НЭГДҮГЭЭР СУВГИЙН ХААЛТТАЙ ХУРАЛ/ЗӨВХӨН УРИЛГААР) (ГХЯ-ны “Номин” танхим)

15:30 - 15:45 Кофе завсарлага (ГХЯ)

**15:45 – 17:00 ХУРАЛДААН 3: ЗҮҮН ХОЙД АЗИ ДАХЬ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СОРИЛТУУД**

Уур амьсгалын өөрчлөлт нь Зүүн Хойд Азийн орнуудын хувьд онцгой чухал асуудал юм. Тус бүс нутаг нь уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын эрс тэс үзэгдэлд ихээхэн нэрвэгдэж, олон хүний амь нас, эрүүл мэнд, амьдрах орчинд аюул учруулсан байгалийн гамшгийн гэрч болоод байна. Үүний зэрэгцээ бүс нутгийн томоохон хүлэмжийн хийн ялгаруулагчдыг уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дорвитой арга хэмжээ авахыг дэлхий нийт уриалсаар байна.

Энэ бүхний улмаас Зүүн хойд Азийн орнууд уур амьсгалын амбицаа нэмэгдүүлж, нүүрстөрөгч багатай, даван туулах чадвартай ирээдүйд чиглэсэн шилжилтийг хурдасгаж байна. Тус хурал нь бүс нутгийн улс орнуудын хамтын ажиллагааны нийтлэг, төвийг сахисан талбар болох уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтарсан үйл ажиллагааг зохицуулах замаар бүс нутгийн яриа хэлэлцээг дэмжинэ гэж найдаж байна. Улмаар итгэлцэл, ил тод байдал, хамтын ажиллагааны дадлыг бий болгоход дэмжлэг болно.

- *Бодлого боловсруулагчид залуучуудын дуу хоолойг сонсож, бодлого боловсруулахад хувь нэмрээ оруулах боломжийг хэрхэн олгох вэ? Залуучуудын мэдлэгийг ямар салбарт нэн тэргүүнд тавих ёстой вэ?*

**Модератор:** Монгол Улсын Онцгой Байдлын Ерөнхий Газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга, доктор **Чадраабалын Ариунаа**

**Панелист:**

Монгол Улс, Байгаль орчны сайд асан, доктор **Замбын Батжаргал**

Киргизийн Стратегийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Засгийн газрын төслүүдийн судалгааны орлогч дарга **Султан Омуров**

Монгол Улсын ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэнгийн ахлах шинжээч **Хүрэлийн Номинболор**

БНХАУ-ын Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны академийн “Бүс ба Зам” судалгааны хүрээлэнгийн судлаач **Ли Чао**

НҮБ-ын Улс төр, Энхийг дэмжих ажиллагааны газрын Ази, Номхон далайн газрын Зүүн Хойд Ази, Номхон далайн багийн Залуучуудын зөвлөх бүлгийн гишүүн **Ижунь Ким** (БНСУ)

Асуулт, хариулт

**18:30 – 20:30** Хүлээн авалт (Шангри-ла зочид буудлын Хүлээн авалтын Их танхим)

**2024 оны 06 дугаар сарын 07, Баасан гараг**

**09:00 – 10:50 ХУРАЛДААН 4: ЗҮҮН ХОЙД АЗИ ДАХЬ ЭРЧИМ ХҮЧНИЙ НАЙДВАРТАЙ, ӨРТӨГ БАГА ШИЛЖИЛТ**

Энэхүү хуралдаанаар Засгийн газрын төлөөлөгчид, бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагааны шинжээч, судлаачид Зүүн Хойд Ази хэрхэн эрчим хүчний шилжилтийн асуудлыг шийдвэрлэх талаар ярилцана. Ялангуяа COP28 болон энэ хүрээнд өрнөж буй үйл явдлуудыг авч үзнэ. НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн зөвлөлөөс SDG7-ийн болон Зүүн Хойд Азийн Ногоон эрчим хүчний коридорын замын зураг гаргах асуудлаар бүс нутгийн орнуудтай хамтран хийсэн ажлын үр дүнд үндэслэн тогтвортой, нүүрстөрөгч бага ялгаруулах эрчим хүчний системд шилжих, түүний ач холбогдлыг хурдасгаж, ашиглахад хоёр болон олон талын хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлэх, үндэсний бодлогыг тодорхойлох асуудлаар ярилцана.

- Зүүн Хойд Азид эрчим хүчний бүтээмжийг дээшлүүлж, нүүрстөрөгчөөс ангижрах зарим шилдэг туршлага, зөвлөгөө юу вэ?
- Зүүн Хойд Азид эрчим хүчний шилжилтийг хийхэд олон талт хамтын ажиллагааны ямар механизм, боломжууд байж болох вэ?
- Зүүн Хойд Азийн эрчим хүчний салбарт ямар төрлийн хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт хамгийн зохистой вэ?

**Модератор:** НҮБ-ын АНДЭЗК-ын Зүүн болон Зүүн Хойд Азийн бүс нутгийн газрын тэргүүн **Баасанжавын Ганболд**

**Илтгэгч:**

НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн, Эрчим хүчний газрын ажилтан **Анис Заман**

“Зүүн Хойд Ази дахь Эрчим хүчний шилжилт, SDG7-гийн Монгол Улсын замын зураглалын байдал: Туршлага, цаашид анхаарах асуудал”

ЕЗГ-ийн Бодлогын ахлах зөвлөх **Мариа Пастухова** (НҮБ-ын АНДЭЗНЗ-ийн төслийн зөвлөх)

“Зүүн Хойд Азийн Ногоон эрчим хүчний коридорын замын зураг: Дараагийн алхмууд”

Токиогийн их сургуулийн дэд профессор **Даниел дел Баррио Алварез**

“Тогтвортой хөгжлийн зорилтууд, Эрчим хүчний холбооны уялдааг үнэлэх хэмжилтийн санаачилгууд”

**Панелист:**

Монгол Улсын Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга **Батмөнхийн Ерэн-Өлзий**

Азийн хөгжлийн банкны Монгол Улс хариуцсан захирал **Шаннон Коулин**

IRENE-гийн хөтөлбөрийн ажилтан **Жүүн Юуп Лий**

БНХАУ-ын Жилиний их сургуулийн Зүүн Хойд Ази судлалын сургуулийн дэд профессор **Чүнжи Шюань**

Асуулт, хариулт

**10:50 – 11:10** Кофе завсарлага (ГХЯ-ны “Номин” танхим)

**11:10 – 13:00 ХУРАЛДААН 5: ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТЭД НЭН ШААРДЛАГАТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТОГТВОРТОЙ, УЯН ХАТАН СҮЛЖЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ**

Энэ хуралдаанд эрчим хүчний шилжилтэд нэн шаардлагатай ашигт малтмалын тогтвортой, уян хатан сүлжээг хэрхэн хөгжүүлэх асуудлыг засгийн газрын болон бүс нутгийн шинжээч, судлаач, холбогдох хүмүүс хэлэлцэнэ. Хуралдаанд оролцогчид нь НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗК, UN ESCAP)-ийн эрчим хүчинд нэн шаардлагатай ашигт малтмалын хангамжийн талаар гүйцэтгэсэн ажил, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тогтвортой хөгжилд шаардлагатай ашигт малтмал олборлох үйл ажиллагааг шинэчлэх ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн Зүүн Хойд Азийн улсууд ашигт малтмалын улам бүр нэмэгдэж буй хэрэгцээг хангах, эрчим хүчний шилжилтийн технологиудын сүлжээг сайжруулах боломжийг нээх асуудлаар хэрхэн хамтран ажиллах боломжтой талаар ярилцана.

- Эрчим хүчний шилжилтэд нэн шаардлагатай ашигт малтмалын тогтвортой, уян хатан сүлжээг хөгжүүлэх энэ болон бусад бүс нутгийн ямар шилдэг туршлага байна вэ?
- Зүүн Хойд Азийн улсууд нэн шаардлагатай ашигт малтмалын тогтвортой хөгжүүлэлтийг хангах НҮБ-ын нөөцийн менежментийн систем, бусад арга хэрэгслийг хэрхэн дэмжих боломжтой вэ?

2024 оны зургаадугаар сарын 04-ний байдлаар

- Тогтвортой, найдвартай, оролцогчдыг хамруулсан нэн шаардлагатай ашигт малтмал, цэвэр эрчим хүчний технологиудын сүлжээг хөгжүүлэхэд улс орнууд хэрхэн хамтран ажиллах боломжтой вэ?

**Модератор:** НҮБ-ын АНДЭЗК-ын Эрчим хүчний газрын Эрчим хүчний уялдаа холбооны хэлтсийн дарга **Мэттью Виттенштейн**

**Илтгэгч:**

Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд **Болдын Уянга**

**Панелист:**

НҮБ-ын Европын Эдийн засгийн комисс (UN ECE)-ийн Тогтвортой эрчим хүчний газрын ажилтан **Харикришнан Тулсайдс**

Монгол Улсын Уулын Баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн Стратегийн бодлогын газрын Хөгжлийн хэлтсийн дарга, доктор **Цэрэндагвын Цэнд-Аюуш**

БНХАУ-ын Жилиний их сургуулийн Зүүн Хойд Ази судлалын сургуулийн профессор **Янь Жао**  
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга, Үндэсний зөвлөлийн гишүүн **Лхагважавын Төр-Од**

Солонгосын Гео шинжлэх ухаан, ашигт малтмалын нөөцийн хүрээлэнгийн ажилтан **Жунхиок Пак**  
ICE-SRM-ийн ОХУ дахь шинжээч, НҮБ-ын Европын эдийн засгийн комиссын нөөцийн менежментийн шинжээчдийн бүлгийн ажлын хэсгийн гишүүн, доктор **Александр Шандрин**

Асуулт, хариулт

**13:00 – 14:00** Өдрийн зоог (ГХЯ-ны “Номин” танхим)

**14:00 – 15:00 ХААЛТЫН ХУРАЛДААН**

**Модератор:** Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэнгийн захирал, доктор **Жаргалсайханы Мэндээ**

**Модераторуудын дүгнэлт** (Хуралдаан 1-5)

Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн шинжээч, Элчин сайд **Очирын Энхцэцэг**  
Франц Улсын Парисын Доуфины Их сургуулийн Улс төрийн шинжлэх ухааны профессор, доктор **Арнод Ливью**

Монгол Улсын Онцгой Байдлын Ерөнхий Газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга, доктор **Чадраабалын Ариунаа**

НҮБ-ын АНДЭЗК-ын Зүүн болон Зүүн Хойд Азийн бүс нутгийн газрын тэргүүн **Баасанжавын Ганболд**

НҮБ-ын АНДЭЗК-ын Эрчим хүчний газрын Эрчим хүчний уялдаа холбооны хэлтсийн дарга **Мэттью Виттенштейн**

**Хаалтын үг:**

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга **Нямдоржийн Анхбаяр**